



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/41

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ний өдрийн XIX/08 дугаар хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймаг Баяннуур сумын төвийн цахилгаан хангамжийн 0.4-10 кв-ын ЦДАШ-ын нэмэлт ажлыг 35,500,000 (гучин таван сая таван зуун мянга) төгрөгөөр “Цац эрчис” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Цац эрчис” ХХК-ийн захирал (Э.Мөнгөнбосго)-д үүрэг болгосугай.

3. Булган аймаг Баяннуур сумын төвийн цахилгаан хангамжийн 0.4-10 кв-ын ЦДАШ-ын нэмэлт ажилд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Баяннуур сумын төвийн цахилгаан хангамжийн 0.4-10 кв-ын ЦДАШ-ын нэмэлт ажлыг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ